



**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН
ҮЙЛДВЭРИЙН ЯАМ
ХҮНСНИЙ НОГООНЫ
ҮЙЛДВЭРЛЭЛ БА УСАЛГААТАЙ
ХӨДӨӨ АЖ АХУЙ ТӨСӨЛ**

МХААХҮХ-ны байр, 5 дугаар давхар, 511 тоот,
Энхтайвны өргөн чөлөө 18A/1,
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13381
Утас: (976) 7711 3895, Цахим шуудан: vria.info@gmail.com

2024. 05. 10 № 02/155
танай _____ -ны № _____ -т

CW-3-1 Услалтын системийг
шинэчлэн сайжруулах барилгын
ажил Эрдэнэбүрэн дэд төсөл
(Эрдэнэбүрэн, Ховд)"-ийн тендерт
оролцогч нарт

Тодруулгын хариу хүргүүлэх тухай

Монгол Улс, Азийн Хөгжлийн Банк хооронд “Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй төсөл”-ийг хэрэгжүүлэхээр 2020 оны 05 дугаар сарын 05-ны өдөр зээлийн хэлэлцээрийг байгуулсан. Тус хэлэлцээрийн 4 дүгээр хавсралтын 3 дугаар заалтад:

“Худалдан авалт

Зээлдэгч нь, Төсөл хэрэгжүүлэгч байгууллагаар дамжуулан доорх заалтыг хангаж ажиллана:

а) Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг Азийн хөгжлийн банкны Худалдан авах ажиллагааны бодлого, Худалдан авах ажиллагааны журмын дагуу гүйцэтгэнэ” гэж заасны дагуу төслийн бүх худалдан авалт нь “Азийн хөгжлийн банкны худалдан авах ажиллагааны журам”-ын дагуу явагддаг.

Тус төслийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө нь (USD) ам.доллараар Азийн хөгжлийн банкнаас батлагдан ирдэг бөгөөд Энэ нь АХБ-ны сайтад ил тодор байршигдсан байдаг Линкийг оруулав. <https://www.adb.org/projects/documents/mon-51423-002-pp>. Энэхүү ам.долларыг тухайн тендерийн баримт бичгийг боловсруулан АХБ-нд хүргүүлэн зөвшөөрөл авах үеийн Монгол банкны тухайн өдрийн ханшинд хөрвүүлэн тооцооллыг боловсруулдаг билээ.

АХБ-ны худалдан авах ажиллагааны журмаар Тендерийн баталгаа нь тооцоолсон төсөвт өртгийн 1-2% байх шаардлагатай тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.2-т заасны дагуу тендерийн баталгааг төсөвт өртгийн 0.5% болгож өөрчлөх боломжгүй юм.

Мөн батлагдсан тендерийн баримт бичгийн 3 дугаар бүлгийн 2.4 -т заасан Барилгын ажлын ижил төстэй ажил гүйцэтгэсэн жилийн хугацааг 4 жил /2020, 2021, 2022, 2023/ болгон өөрчилж инженер техникийн ажилтнуудыг дараах байдлаар өөрчилж тендерийн баримт бичигт өөрчлөлт оруулж байна.

№	Ажлын байрны нэр	Тоо	Нийт ажлын туршлага, жилээр	Ижил төстэй ажлын туршлага, жилээр
1	Төслийн ерөнхий инженер (дор хаяж усны барилгын мэргэшсэн эсхүл зөвлөх инженерийн зэрэгтэй байх)	1	10≤	5≤
2	Барилгын инженер	1	5≤	3≤

3	Усны барилга байгууламжийн инженер	2	5≤	3≤
4	Механик инженер	1	5≤	3≤
5	Геодезийн инженер	1	5≤	3≤
6	Ус хангамж ариутгах татуургын инженер	1	5≤	3≤
7	Тоног төхөөрөмжийн инженер	1	5≤	3≤
8	Гидромеханик ба сатехникийн инженер	1	5≤	3≤
9	Эрүүл мэнд, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны инженер	2	5≤	3≤
10	Байгаль орчны мэргэжилтэн	1	5≤	3≤
11	Төслийн админ-бичиг хэрэг	1	2≤	2≤
12	Бетон арматурчин	1	5≤	3≤
13	Гагнуурчин	1	5≤	3≤
	Нийт	15		

ГТБХЗГ-ын зохицуулах газрын Хөрс,
ургамал хамгаалал,
үр сортын хэлтсийн дарга бөгөөд
Төслийн захирал



Н.ОЮУНСУВД